

**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/30

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Инновэйшн Инвестмент ХК-ийн Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2024 оны хоёрдугаар хагас жилийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 20 /хорь/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2024 оны хоёрдугаар хагас жилийн цэвэр ашгийн 77.8 /дал долоо аравны найм/ хувь буюу 3,697,783,200.00 /гурван тэрбум зургаан зуун ерэн долоон сая долоон зуун наян гурван мянга хоёр зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Компани нь 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 05/14 тоот тогтоолоор 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар зарласан ба нэгж хувьцаанд 20 /хорь/ төгрөг буюу нийт 3,697,783,200 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр олгосон тул 2024 онд тайлант жилийн цэвэр ашгийн 73.8 /далан гурав аравны найм/ хувь буюу нийт 7,395,566,400 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж байгааг дурьдсугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуй нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашгийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хуваарилахаар тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР